

ЭРДЭНЭ РЕСУРС ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот
2019.06.21

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь 2019 оны 6-р сарын 20-нд Нова Скошиа мужийн Халифакс хотод зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын (“AGM”) үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үр дүнгийн дэлгэрэнгүйг доор харуулав.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Компанийн хөгжил дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулсан ТУЗ-ийн дарга асан Крис Кованд ТУЗ-ийн өмнөөс талархал илэрхийлж байна. Тэрээр Эрдэнэ Ресурсийг үүсгэн байгуулагдсан цагаас анхны хайгуулын хөтөлбөрөөс эхлэн, Монгол улсын баруун өмнөд хэсэгт Хөндий Алтны Төслийг нээн илрүүлэх хүртэл компанийн хөгжлийн бүх үе шатуудад үнэтэй хувь нэмэр оруулж байсан.”

“Мөн Лэйтон Крофтыг Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн даргын албан тушаалд шинээр томилогдож байгаад бид баяртай байна. Тэрээр 2015 оны 6-р сараас хойш Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд Монгол улсад Оюу Толгой (“Айванхоу Майнз, Рио Тинто”), Саусгоби Ресурс, Пийбоди Энержи зэрэг уул уурхайн компаниудад 25 жил ажилласан туршлагатай. Тэрээр удирдлага, харилцааны арвин туршлага, мэдлэгтэй бөгөөд компанийн Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн үйл явцад үнэ цэнийг нэмэгдүүлэн үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэж байна” хэмээв.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хувьцаа эзэмшигчид Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн гишүүдийн төлөө санал өгч, сонгосон бөгөөд санал хураалтын үр дүнг доор харуулав.

Нэр дэвшигч	Зөвшөөрсөн	Зөвшөөрсөн %	Татгалзсан	Татгалзсан %
Петер К.Акерли	47,295,840	99.93	34,350	0.07
Др. Анна Г.Биолик	47,307,076	99.95	23,114	0.05
Жон П.Бюрн	47,306,076	99.95	24,114	0.05
Т.Лэйтон Крофт	46,098,910	97.40	1,231,280	2.60
Кеннет В.МакДоналд	47,292,576	99.92	37,614	0.08
Камерон МакРэй	47,315,790	99.97	14,400	0.03
Дэвид В.Мошер	47,292,576	99.92	37,614	0.08

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараа ТУЗ нь дараах удирдлагын багийг томилов. Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал – Петер Акерли, ТУЗ-ийн дарга – Т.Лэйтон Крофт, Санхүү хариуцсан захирал – Роберт Женкинс, Компанийн нарийн бичгийн дарга – Сюзан Фрэйзр нар томилогдлоо.

Аудиторыг дахин томилох

Компанийн аудиторор Кэй Пи Эм Жи ХХН (“KPMG LLP”) компанийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал, эсвэл өөр компанийг томилох хүртэл дахин сонгож, ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олголоо.

Хуваарилагдаагүй опционыг батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу Компанийн 10%-ийн хуваарилагдаагүй опционы урамшууллын хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих бүх хуваарилагдаагүй опционыг батлахыг хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах

Хувьцаа эзэмшигчид Компанийн ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. Энэхүү ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн Удирдлагын мэдээллийн танилцуулга, мөн www.sedar.com дахь компанийн хуудсаас танилцах боломжтой.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
Twitter: <https://twitter.com/ErdeneRes>
Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>
LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>
YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>